



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2016 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 04

Өлгий

Засгийн газрын "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай"
албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай

Аймгийн хэмжээнд шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах, "Хариуцлагын жил"-ийн хүрээнд хийх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын албан даалгавар өгч байна.

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын дарга нарт

1.1. Иргэнд ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах.

1.1.1. Байгууллагын ёс зүйн дүрэм, Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтан, албан хаагчдыг Ёс зүйн хорооны хурлаар авч хэлэлцэн сахилгын шийтгэл ногдуулах, гарсан шийдвэрийг ил тод мэдээлэх.

1.1.2. Төрийн албан хаагч нь ажлаа оновчтой төлөвлөж, идэвх санаачлагатай ажиллах бөгөөд мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж, ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглаж ажиллах.

1.1.3. Хэлтэс, агентлагийн дарга нар албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

1.1.4. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид байж, бие биенээ хүндэтгэн, хамт олонч, захирах, захирагдах ёсыг чанд баримтлан ажиллана.

1.1.5. Албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд сахилга хариуцлага, ёс зүйг чандлан сахих талаар тусгасныг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан үнэлж, дүгнэх

1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх

1.2.1. "Авлигын тухай хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г мэдээллийн самбар, цахим хаягт байршуулж, албан хаагчдад сурталчлах.

1.2.2. Албан хаагчдыг авилга, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, давтан сургалтыг зохион байгуулах

1.2.3. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг эрх бүхий албан тушаалтанд тухай бүрт нь мэдээлэх, авлигын шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх.

00000008

1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах

1.3.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг нээлттэй хүлээн авч хуулийн хугацаанд шуурхай эцэслэн шийдвэрлэх.

1.3.2. Өргөдөл гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх. /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр/.

1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих

1.4.1. Хэлтэс, агентлагийн дарга нар байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан дүрэм, журмыг албан хаагч нэг бүрээр судлуулж, мөрдлөг болгон ажиллах.

1.4.2. Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж, албан хаагчдын хувцаслалт, ажлын бүтээмжийг сайжруулахаас гадна цаг ашиглалтын байдалд өдөр тутам хяналт тавих.

1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх

1.5.1. Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор тэднийг мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтад байнга хамруулж, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд онцгой анхаарах

1.5.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд санаачлагатай ажиллах

1.5.3. Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлээр хангана.

2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга, сумдын Засаг дарга нарт:

2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах

2.1.1. Сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг байгууллага тус бүр дээр хийж, албан хаагчдын сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт өгч тайланг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлэх.

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах

2.2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах.

2.2.2. Тендерийн баримт бичиг, урилга болон холбогдох хууль тогтоомжийг цахим хуудсандаа байршуулах

2.2.3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах.

2.2.4. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.

2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх

2.3.1. Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулах.

2.3.2. Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж, тогтмол баяжуулан байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.

2.3.3. Нэг цэгийн үйлчилгээний ажлыг эрчимжүүлэх, хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлж эхлэх

2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх

2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах

2.5.1. Албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх замаар шагнаж, урамшуулах.

3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна

3.1. Батлагдсан төсөвт багтаан зардлыг хэмнэж, өр, авлага үүсгэхгүй ажиллана.

3.2. Төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжих тухай Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолыг чанд мөрдөж ажиллана.

3.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлан, балансыг хуулийн хугацаанд гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагч болон холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

3.4. Албан хаагч нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан хэрэглэж байсан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж түүнчлэн эд материалыг үрэгдүүлсэн бол Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нөхөн төлүүлэх

4. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг даалгаж байна.

5. "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" МУ-ын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр даалгаврыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг баталж, мөрдөж ажиллах.

5.1. Байгууллагын цахим хаягт байршуулж, тусгайлсан самбар гаргах,

5.2. Албан даалгаврыг хэрхэн биелүүлэх талаар түргэвчилсэн сургалт зохион байгуулж, албан хаагчдаас шалгалт авч, дүнг илтгэх хуудсаар танилцуулах, шалгалтын дүнг албан хаагчийн жилийн эцсийн ажлын үзүүлэлттэй уялдуулан үр дүнгийн гэрээг дүгнэх.

5.3. Шалгалт авч дүнг илтгэх хуудсаар ирүүлээгүй, тусгайлсан самбар гаргаагүй, албан хаагч нэг бүрт судлуулж тэмдэглэл хийлгээгүй сумдын Засаг дарга, хэлтэс агентлагийн дарга нарт хариуцлага тооцно.

Энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, тайлангаа 06 дугаар сарын 20, 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Тилеген/д- хариуцуулж байна.

ЗАСАГ ДАРГА  А.ГЫЛЫМХАН

